




ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН

ЖИЛИЙН ТАЙЛАН 2022

УЛААНБААТАР




1.

Орос-Украины дайны Монголын өрх, аж ахуйн нэгжүүдэд үзүүлэх нөлөөллийн түргэвчилсэн үнэлгээ




2.

Нүүрсний салбар дахь АМНАТ-ийн зохицуулалтын олон улсын ба дотоодын туршлагын судалгаа




3.

Монголын макро эдийн засгийн судалгаа



4.

Тооцоолох Ерөнхий Тэнцвэрийн загвар ба Монголын эдийн засгийн бодлогын симуляц




5.

Цар тахлын үеийн эдийн засгийн бодлого: Өнгөрсөн ба ирээдүй



6.

Бага, дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг тооцох аргачлал боловсруулах, турших



7.

Монгол улсын зудын эрсдэлийг бууруулах арга хэмжээ (цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээ) болон малчдын зудыг тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх төслийн мэдээлэл цуглуулах судалгаа

8.

Сумдын орон нутгийн хөгжлийн сангийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээ – 2022

9.

2022 оны хурал

ТАЙЛАН

Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн (ЭЗСЭШХ) нь 2010 онд байгуулагдсан. ЭЗСЭШХ нь мэргэжлийн өндөр түвшний, хараат бус, оновчтой асуудал дэвшүүлсэн бодлогын шинжилгээ, судалгааны ажлыг хийх, үр дүнг нийтэд ойлгомжтой байдлаар мэдээлэх зорилготой. Мөн бид бодлогын судалгаа хийх хэрэгцээг тодорхойлж, голлох салбаруудад чиглэсэн хараат бус, чанартай судалгааны ажил хийж, мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг. 2022 онд бид ЖАЙКА, UNDP, USAID-ийн BEST хөтөлбөр, Дэлхийн банкны Тогтвортой амьжиргаа III төсөл зэрэг олон улсын байгууллагууд болон УУХҮЯ, ЭЗХЯ, БШУЯ-ны харьяа Боловсролын хүрээлэн, Нүүрс ассоциаци зэрэг дотоодын байгууллагуудын захиалгат судалгааг хийж, зөвлөх үйлчилгээ үзүүлж ажиллалаа. Түүнчлэн, бид ЖАЙКА болон УУХҮЯ-тай хамтран 2016- 2022 онд хэрэгжүүлсэн “Монголын ашигт малтмал, уул уурхайн салбарын судалгааны чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийг амжилттай хаалаа. Тус төслийн гол бүтээгдэхүүн болох судалгааны ажлуудыг нэгтгэж “Монголын эдийн засгийн уул уурхайн салбараас хараат байдал” номыг Springer хэвлэлийн газрын “Эдийн засагт оруулсан хувь нэмэр” цувралын нэг болгон хэвлүүлснийг онцлох нь зүйтэй.

ОРОС-УКРАИНЫ ДАЙНЫ МОНГОЛЫН ӨРХ, АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ТҮРГЭВЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ

ЭЗСЭШХ нь энэхүү түргэвчилсэн үнэлгээг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн захиалгаар, НҮБ-ын агентлагуудын дэмжлэгтэйгээр гүйцэтгэлээ. Үнэлгээний гол зорилго нь 2022 оны 3-р сараас 9-р сарын хооронд Монгол Улсын өрхийн амьжиргаа, бизнесийн орчинд Орос-Украины дайн болон цар тахлын үзүүлсэн нөлөөг тодорхойлоход оршино. Мөн энэ судалгаагаар эдгээр хямралын нөлөөллийг бууруулах, нөлөөлөлд өртсөн бүлгүүдийг дэмжихэд шаардлагатай арга хэмжээг тодорхойлох зорилго тавьсан. Гэхдээ дээрх хугацаанд бизнесийн орчин болон өрхүүдийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалд тулгарч буй асуудлууд нь Орос-Украины дайны шууд бус нөлөөллөөс гадна Ковид-19 цар тахлын үргэлжилсэн нөлөө, Хятадын "Тэг-Ковид" бодлого болон Засгийн газраас 2021 онд хэрэгжүүлсэн "10 их наядын хөтөлбөр" зэрэг бусад үйл явдлын нөлөөнөөс үүдэлтэй болохыг анхаарах хэрэгтэй юм.

Аргачлал

Энэхүү түргэвчилсэн үнэлгээний хүрээнд Улаанбаатар хот, Баян-Өлгий, Ховд, Сэлэнгэ, Архангай, Өмнөговь, Дорнод аймгийн 602 зорилтот бүлгийн өрх, 80 аж ахуйн нэгж, 20 орон нутгийн удирдлагын төлөөлөлтэй ярилцлага хийсэн. Зорилтот бүлгийн өрхүүдийг сонгохдоо Нийгмийн хамгааллын тухай хуульд заасан олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ авах бүлгүүдээс дараах шинж чанар бүхий өрхүүдийг хамруулав. "Хөгжлийн бэрхшээлтэй болон тусгай хэрэгцээт иргэн бүхий өрх" "гурав ба түүнээс олон хүүхэдтэй эмэгтэй тэргүүнтэй өрх" "ахмад тэргүүнтэй өрх, залуу тэргүүнтэй эмзэг бүлгийн өрх" "сүүлийн хоёр жилд албан ба албан бусаар шилжиж ирсэн эмзэг бүлгийн өрх" "хүнсний талон авдаг өрх" "ганц бие ахмад настан" Мөн нийт өрхүүдийн амьжиргаанд үнийн өсөлтийн үзүүлж болзошгүй нөлөөллийг үнэлэхийн тулд Үндэсний статистикийн хорооны 2021 оны Өрхийн нийгэм-эдийн засгийн түүвэр судалгааны 11,199 өрхийн анхдагч тоон өгөгдөлд симуляц шинжилгээ хийсэн. Бизнесүүдийн хувьд, хямралын нөлөөнд хамгийн түрүүнд өртөж болзошгүй, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдээс судалгаанд хамруулж, ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулсан.

Гол үр дүн

Үнийн өсөлтийн өрхөд үзүүлэх нөлөө

Орос-Украины дайн нь дэлхийн зах зээл дээрх хүнсний болон нефтийн үнийг өсгөсөн. Энэ нөлөө нь Ковид-19-тэй холбоотой нийлүүлэлтийн тасалдал, зээлийн тэлэх бодлоготой холбоотой эрэлтийн өсөлтийн улмаас угаас өндөр байсан Монгол Улсын инфляцыг улам нэмэгдүүлсэн юм.

Зураг 1. Инфляц хэрэглээний арван бүлгээр, 2021 оны 9-р сартай харьцуулснаар



Эх сурвалж. УСХ-ны ӨНЭЗС-2021 анхдагч өгөгдөлд суурилсан судлаачдын тооцоо

Үнийн өсөлт нь орлого багатай өрхүүдэд илүү их дарамт учруулж байна. Тухайлбал, 2022 оны 7-р сарын байдлаар хамгийн бага хэрэглээтэй өрхүүдийн инфляцын дарамт хамгийн өндөр хэрэглээтэй бүлэгтэй харьцуулахад 5.3 нэгж хувиар их байв.

Ялангуяа, үнийн өсөлтийн дарамт хамгийн ихээр мэдэрч буй хэсэг нь гурав ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эцэг эх, хөгжлийн бэрхшээлтэй болон онцгой анхаарал халамж шаарддаг гишүүнтэй өрхүүд байна. Мөн өрх толгойлсон эмэгтэйчүүдийн хувьд инфляцын дарамт бусад өрхтэй харьцуулахад 1-2 нэгж хувиар их байна. Бүтээгдэхүүнээр авч үзвэл гурилын үнийн өсөлт нь гурав ба түүнээс дээш хүүхэдтэй ганц бие эцэг/эх-д бусад бүлгүүдээс их ачааллыг үүсгэжээ. Түүнчлэн, малчид өдөр тутмын аж ахуйн үйл ажиллагаанд автомашин, ачааны машин ашигладаг тул шатахууны үнийн өсөлт тэдний төсөвт илүү их дарамт үзүүлж байна.

Зорилтот бүлгийн өрхүүдийн нийгэм-эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал

Судалгааны үр дүнгээс харахад зорилтот бүлгийн өрхүүдийн орлогын хүрэлцээ хангалтгүй байна. Тухайлбал, гурав ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх, хүнсний талон авдаг өрх, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхүүд өдөр тутмынхаа хэрэгцээг ч хангаж чадахгүй байна. Өрхийн өдөр тутмын хэрэгцээг хангаж чадахгүй байдал өрх толгойлсон эмэгтэйчүүдийн дунд илүү ажиглагджээ.

Судалгаанд хамрагдсан өрхүүдийн 67%-ийн өрхийн амьжиргаа 2022 оны 3-р сараас хойш дорджээ. Үүнд орлого багатай байдал, хүнс, шатахууны үнийн өсөлт голлон нөлөөлсөн. Тухайлбал, судалгаанд хамрагдсан өрхүүдийн 26%-ийн нь орлого 2022 оны 3-р сараас хойш буурчээ. Үүнээс үүдэн шинэ хувцас авч чадахгүй байх, зээлийн төлбөрөө төлөхгүй, өдөр тутмын хоол хүнс, хүнсний бараагаа авахад тусламж хэрэгтэй болох зэрэг олон асуудал тулгарчээ.

Зураг 2. Өрхийн орлого буурсантай холбоотой тулгарч буй бэрхшээлүүд, хувийн жин



Орлого буурсан, бүтээгдэхүүний үнийн өссөнтэй холбоотойгоор өрхүүд хэрэглээгээ бууруулж байна. Тухайлбал, гурав ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх, хүнсний талон авдаг өрх, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхүүдийн хувьд хэрэглээгээ бууруулах хандлага их байна. Хөдөө орон нутгийнхаас илүү хотод оршин суудаг өрхүүдийн хэрэглээ буурчээ.

Үнэ өссөн үед эмзэг бүлгийн өрхүүд хувцас, гэр ахуйн хэрэгсэл, түлш цахилгаан, тээврийн зардал гэх мэт зардлаа хамгийн эхэнд танасан. Мөн зорилтот бүлгийн өрхүүд мах, гурил, хүнсний ногоо зэрэг гол хүнсний бүтээгдэхүүний хэрэглээгээ багасгажээ. Хүнсний хэрэглээ багассан өрхүүд хямд эсвэл чанаргүй хоол хүнс хэрэглэж, насанд хүрэгчдийн, болон хүүхдүүдийн өдөрт хооллох давтамж эсвэл хоолны хэмжээг багасгах арга хэмжээ авч байна. Энэ нь зорилтот бүлгийн өрхүүдийн шим тэжээлийн дутагдал, хүнсний хомсдолд орох эрсдэл улам нэмэгдэж байгааг харуулж байна.

Бизнес эрхлэгчдэд тулгамдаж буй асуудлууд

Ковид-19 цар тахлын оргил үед үүссэн бараа түүхий эдийн тасалдал, хүний нөөцийн хомсдол, борлуулалтын орлогын бууралт бүрэн сэргэж амжаагүй, сөрөг нөлөө нь үргэлжилж байгаатай холбоотойгоор жижиг дунд аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа хүндрэл ихтэй байна. Түүнчлэн, Орос-Украины дайны улмаас ОХУ-аар дамжих тээвэр саатсан бол дотоодын бизнес эрхлэгчдийн худалдааны гол түнш болох БНХАУ-ын “Тэг Ковид” бодлогын улмаас тус улсаас импортлох болон дамжих тээвэрлэлт удаашралтай байна. Энэ нь боловсруулах үйлдвэрлэл, худалдаа эрхлэгчдэд хүндрэл учруулж байна. Мөн цар тахлын үеийн хатуу хөл хорионы нөлөөгөөр түр болон бүрмөсөн гарсан ажилтнууд, ялангуяа, залуу эмэгтэйчүүд ажилдаа эргэж орох нь удаашралтай байгаа нь оёдол, худалдаа, үйлчилгээний салбарын сэргэлтэд сөрөг нөлөө үзүүлжээ. Бараа түүхий эдийн үнэ хурдтай өсөж байгаа нь бүхий л аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.

Санал, зөвлөмж

Иргэд, аж ахуйн нэгжүүдэд тулгарч буй дээрх асуудлуудтай холбоотойгоор дараах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

- Эмзэг бүлгийн хүүхдүүдийн хүнсний хэрэглээ буурах ноцтой эрсдэл тулгарч байгаа тул сургууль, цэцэрлэгийн хоол хүнсний хүрэлцээ хангамж, чанарыг сайжруулах замаар шим тэжээлийн дутагдлаас сэргийлэх.
- Үнийг тогтворжуулахын тулд богино хугацаанд мах, гурил, хүнсний ногоо, бензин шатахууны хангамжийг нэмэгдүүлэх, нөөц бүрдүүлэх.
- Суурь инфляцыг бууруулах мөнгөний бодлого хэрэгжүүлэхдээ эмзэг бүлгийн өрхүүд болон жижиг бизнесүүдэд тулгарах сөрөг нөлөөг аль болох бага байлгах зохицуулалт хийх.
- Эмзэг бүлгийн иргэдийн тэтгэвэр, тэтгэмжийг инфляцтай уялдуулан өсгөх, эдгээр иргэд түлхүү ажил эрхэлдэг ЖДҮ, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн бизнесийн боломжийг илүү нээж өгөх.
- Хүүхдийн мөнгө гэх мэт хамрагдалт ихтэй халамжийн хөтөлбөрийг зорилтот бүлгүүдэд илүү чиглүүлэх.
- Түлш шатахуун, үр, бордоо, ХАА-н тоног төхөөрөмж импортолдог улс орнуудын тоог нэмэгдүүлэх.
- Хөнгөлөлт, дэмжлэгийн хөтөлбөр хэрэгжүүлэхдээ орлогын хуваарилалтын нөлөөг нь урьдчилан тооцдог байх.
- Төсвийн үр ашиггүй зардлуудыг ихээр танах, төрийн оролцоог бууруулах, төрийн өмчийн ААН-үүдийг татан буулгах, хувьчлах реформуудыг хийх.
- НӨАТ, ХХОАТ, ААНОАТ, Малын татвар зэрэг татварын суурийг тэлэх буюу татвар төлбөл зохих бүх иргэд, ААН-үүдийг жигд хамруулах, татвараас зайлсхийх явдлыг таслан зогсоох.

НҮҮРСНИЙ САЛБАР ДАХЬ АМНАТ-ИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОЛОН УЛСЫН БА ДОТООДЫН ТУРШЛАГЫН СУДАЛГАА


Энэ судалгааг “Монгол нүүрс ассоциаци”-ийн захиалгаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон нүүрс экспортлогч компаниудын дэмжлэгтэйгээр хийж гүйцэтгэв. Ковид-19 цар тахлын хүндрэлтэй зэрэгцэн ЗГ-ын 2021 оны 174-р тогтоолоор экспортын нүүрсний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ) ногдуулах борлуулалтын үнэлгээг жишиг үнэд суурилан тооцох болсноос үүдэн нүүрс экспортлогчид хэт өндөр АМНАТ төлөх асуудал үүссэн. Үүнтэй холбоотойгоор энэ судалгаанд уул уурхайн салбарт АМНАТ ногдуулах олон улсын ба дотоодын туршлагыг харьцуулж, АМНАТ-ийн зохицуулалттай холбоотой үүсээд байгаа асуудлыг нарийвчлан судалж, санал зөвлөмж дэвшүүлэхийг зорьсон.

АМНАТ-ийн зохицуулалтын талаарх олон улсын туршлагыг Австрали, Индонези, ОХУ, БНХАУ-ын жишээн дээр авч үзсэн. Харин АМНАТ-ийн зохицуулалтын дотоодын туршлагыг уул уурхайн салбарын тоон мэдээлэл, бодлогын болон судалгааны баримт бичгийн хүрээнд шинжилж, АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээг жишиг үнэд суурилан тооцох аргачлалтай холбоотой асуудлыг нарийвчлан судалсан.

Зураг 1. Боловсруулаагүй коксжих нүүрс, мянган төгрөг/тонн



Зураг 2. Нүүрс экспортлогчдын АМНАТ ба борлуулалтын орлогын харьцаа



Эх сурвалж: АМГТГ, ГЕГ, EITI, Нүүрс ассоциаци, судлаачийн тооцоолол

Судалгааны гол үр дүн

АМНАТ-ийн зохимжтой хувь хэмжээ, татварын бодлого

- АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээг бодит байдлаас хэт өндрөөр тооцож татвар ногдуулах нь үнэн хэрэгтээ АМНАТ-ийн хуульд заасан хувь хэмжээг далд байдлаар өсгөхтэй адил. Иймд энэ нь татварын суурийг хумьж, төсвийн орлогыг бууруулж болзошгүй.
- Манай улсад АМНАТ болон бусад татварын оновчтой хэмжээг тооцож тогтоосон судалгаа байдаггүй. Ийм тооцооллыг онолын загвар дээр туршиж, салбарын оролцогчдын санаа бодлыг тусгаж, хэлэлцүүлж байж тогтоох учиртай.
- Ковид-19 цар тахлын сөрөг нөлөөнд уул уурхайн салбар, тэр дундаа тээвэр, логистикоос өндөр хамааралтай нүүрсний салбар хамгийн хүчтэй өртсөн тул цар тахлын хүндрэл, хохирлыг нөхөх боломж олгох нь чухал.
- Уул уурхайн компаниудын төлсөн татвар, АМНАТ-ийн мэдээллийн хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх шаардлагатай.

Нүүрсний жишиг үнэ тооцох аргачлал

- Нүүрсний тээврийн зардал нь жишиг үнэ ба борлуулалтын үнийн зөрөөг голлон тодорхойлж байна.
 - Энэ нь дэд бүтцийн сул хөгжил, зохион байгуулалтын хомсдолоос шалтгаалдаг. Ковид-19-ийн үед тээврийн зардал огцом нэмэгдсэн.
 - Энэ нь тээвэрлэлт дүрэм журамгүй, зохион байгуулалтгүй, үр ашиггүй, авлигатай холбогдсоны илрэл.
- Жишиг үнийг хэрхэн тооцож буй аргачлал ил тод биш, эргэлзээ төрүүлэхүйц байна. <http://en.sxcoal.com> цахим хуудасны мэдээлэлд үндэслэн жишиг үнийг тогтоохдоо уг эх сурвалжийн аль боомтын, ямар зэрэглэлийн нүүрсний үнийг хэрхэн сонгож байгаа нь тодорхой бус.
- Жишиг үнэ тооцохдоо <http://en.sxcoal.com>-д зарласан үнээс БНХАУ-ын НӨАТ-ыг хасдаг боловч хасвал зохих импортлогч талын бусад татвар, зардлуудыг хасдаггүй.
- Нүүрс экспортлогч компаниуд, АМГТГ энэ аргачлалын талаар тодорхой мэдээлэлгүй байна. Гэтэл бусад орны аргачлал ил тод, ойлгомжтой (Индонез, ОХУ гэх мэт).
- Жишиг үнэ тооцох аргачлал маш олон удаа өөрчлөгдөж ирсэн бөгөөд тэр бүрийд ямар тооцоо, бодит шаардлагад үндэслэсэн судалгаа баримт байгаагүй.

Санал зөвлөмж

- Ковид-19-ийн үед нүүрсний салбарын үйл ажиллагаа ихээр доголдож, эдийн засгийн өсөлт саарсан үед АМНАТ тооцох аргачлалыг эргэн харж өөрчлөх хэрэгтэй. Ингэснээр нүүрс экспортлогчдын татварын дарамт ба АМНАТ-ийн өр нэмэгдэх, татварын маргаан гүнзгийрэхээс сэргийлнэ.
- Нүүрс тээврийн зардлыг бууруулах зохион байгуулалтын арга хэмжээг авах. Тээвэр зуучийн олон компаниудын үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, үр ашиггүй өрсөлдөөний зардлыг хэмнэх, авлигыг бууруулах.
- Нүүрс экспортлогчдын борлуулалтын гэрээг аль болох экспортын гааль хүрэх нөхцөлөөр (FCA, CIP, DAP гэх мэт) байгуулахыг дэмжих.
- Жишиг үнийг хэрхэн тооцож буй аргачлалыг ил тод, нээлттэй болгох.
- Жишиг үнэ тогтоох ажлын хэсэгт нүүрс олборлогчид, уул уурхайн салбарын төлөөллийг хангалттай оруулах.
- АМНАТ ногдуулахтай холбоотой бодлого, журмыг тогтвортой мөрдөх.
- Уул уурхайн бирж байгуулахтай уялдуулан нүүрсний АМНАТ тооцох асуудлыг судалж эхлэх.
- Уул уурхайн салбарт, улмаар нийт эдийн засагт татварын бодлогын үзүүлэх нөлөөллийн судалгааны суурь тоон загвар боловсруулж, хувилбар тооцоог шийдвэр гаргахаас өмнө хийж туршдаг болох.

МОНГОЛЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА

Японы Жайка байгууллагын захиалгаар гүйцэтгэсэн энэхүү судалгаа нь Монголын макро эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлыг тогтмол судалж, гарсан өөрчлөлтийн шалтгаан, цаашдын хандлагыг дүгнэх зорилготой. Судалгааны хүрээнд улирал тутмын тоон мэдээлэл, түүний өөрчлөлт, сүүлийн үеийн хандлагын талаар дэлгэрэнгүй тайлан бэлтгэдэг. Мөн сар тутмын макро эдийн засгийн мэдээний тойм бэлтгэж, захиалагчийг мэргэжлийн түвшинд бэлтгэсэн судалгаа, мэдээллээр тогтмол хангаж ирсэн. Тус судалгаагаар эдийн засгийн өнөөгийн байдал, бодлогын асуудал, эдийн засагт тулгарч буй эрсдэлүүд гэсэн гурван гол хүрээг авч үздэг.

Эдийн засгийн өнөөгийн байдлын талаар судлахдаа эдийн засгийн өсөлт, салбаруудын гүйцэтгэл, арилжааны банкнуудын зээлийн үлдэгдэл, төлбөрийн тэнцлийн улирал бүрийн тоон мэдээллийг цуглуулж, нэгтгэн дүгнэдэг. Түүнчлэн өрхийн сарын дундаж орлого болон зарлаг, цалин, валютын нөөц, төгрөгийн ханшийн өөрчлөлтүүд, цаашдын хандлагын талаар дэлгэрэнгүй танилцуулгаар хангаж ирлээ. Монголын эдийн засаг хэр идэвхтэй байгааг тодорхойлохын тулд “Эдийн засгийн хэт халалтын индекс”-ийг улирал бүрээр тооцон, дүн шинжилгээ хийдэг.

Энэхүү индекс нь эдийн засгийн өсөлт, инфляц, ажил эрхлэлт зэргээс гадна бодит хүү, урсгал тэнцэл, зээлийн илүүдэл өсөлт зэрэг макро эдийн засгийн бусад үзүүлэлтийг нэгтгэн илэрхийлдэг[1]. Уг тооцооноос харахад индексийн утга сүүлийн 4 улирал өндөр түвшинд хадгалагдав (Зураг 1). Энэ нь цар тахлын улмаас буураад байсан эдийн засгийн идэвхжил сэргэж байгаагийн илрэл юм. Хэдийгээр эдийн засаг уналттай, ажилгүйдэл харьцангуй өндөр байгаа боловч инфляц, урсгал тэнцлийн алдагдал, зээлийн илүүдэл өсөлт өндөр байгаа нь үүнд голлон нөлөөлөв.

[1] Дэлгэрэнгүй тайлбарыг Монголбанкны “Судалгааны ажил – Товхимол 10”, 2015-д нийтлэгдсэн “Бодлогын орон зайн индекс” тайлангаас үзнэ үү.
<https://www.mongolbank.mn/documents/tovhimol/group10/10-16.pdf>.

Бодлогын асуудлын тухайд улсын төсөв, засгийн газрын өр, мөнгөний нийлүүлэлтийн талаар дэлгэрэнгүй авч үздэг. Түүнчлэн судалгааны баг эконометрикийн загвар ашиглан эдийн засгийн өсөлтийн богино хугацааны таамаглал дэвшүүлдэг. Мөн эдийн засагт эрсдэл тулгарсан үед макро бодлогын тэлэх орон зай байгаа эсэхийг судалж, дүгнэлт гаргасан. Үүний хүрээнд “Эдийн засгийн бодлогын орон зайн индекс”-ийг улирал тутам тооцоолж байна. Бодлогын орон зайн индекс 100-д дөхөж, их байх тусам тэлэх бодлого явуулах боломж нэмэгдэж байгааг харуулах бол индексийн утга 0-д дөхөж, бага байх тусам тэлэх бодлого хэрэгжүүлэх орон зай хумигдаж байгаа харуулна[2]. Бодлогын нийт орон зайг тус бүр 50 оноо бүхий сангийн ба мөнгөний бодлогын орон зайн нийлбэрээр тодорхойлдог.

Уг индексийн динамикийг Зураг 2-т харуулав. 2022 оны III улирлын байдлаар уг индексийн утга 13 болж 2013 оноос хойших хамгийн доод түвшинд хүрээд байна. Инфляц өндөр, урсгал тэнцлийн алдагдал их, бодит хүү сөрөг, төгрөгийн ханш уналт их байсан тул мөнгөний бодлогын орон зай эрс хумигдав. Төсвийн алдагдал их, засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь өндөр байсан тул сангийн бодлогын орон зай ч бага байна. Өөрөөр хэлбэл, эдийн засагт хүчтэй уналт, хямрал тохиолдсон үед Засгийн газар, Монголбанк нөөцөөрөө ямар нэг тэлэх бодлого явуулах боломж бараг байхгүй болжээ.

Монголын макро эдийн засгийн судалгааны нэг зорилго нь цаашид эдийн засагт тулгарч болох эрсдэлүүдийг үнэлэх явдал юм. Энэ хүрээнд түүхий эдийн үнийн хэлбэлзэл, Орос-Украины дайн, Хятадын “Тэг Ковид” бодлого, дотоодын улс төрийн тогтворгүй байдал зэрэг томоохон эрсдэлүүдийг судалгаанд дэлгэрэнгүй авч үзсэн.

[2] Дэлгэрэнгүй тайлбарыг Монголбанкны “Судалгааны ажил – Товхимол 10”, 2015-д нийтлэгдсэн “Бодлогын орон зайн индекс” тайлангаас үзнэ үү. <https://www.mongolbank.mn/documents/tovhimol/group10/10-16.pdf>.

ТООЦООЛОХ ЕРӨНХИЙ ТЭНЦВЭРИЙН ЗАГВАР БА МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН СИМУЛЯЦ

ЭЗСЭШХ нь ЖАЙКА болон Эдийн засаг, хөгжлийн яам (ЭЗХЯ)-ны хүсэлтээр “Тооцоолох Ерөнхий Тэнцвэрийн (CGE) загварчлал ба Монголын эдийн засгийн бодлогын симуляц” төсөлд зөвлөх үйлчилгээ үзүүлсэн. Энэхүү төслийн гол зорилго нь ЭЗХЯ-ны ажилчдад CGE загварчлал ба түүний хэрэглээний сургалт зохион байгуулж, мэдлэг эзэмшүүлэх байв. Тус төслийн хүрээнд ЭЗСЭШХ-ий судлаачид CGE загварчлалын сургалтын хэрэглэлүүдийг бэлтгэж, ЭЗХЯ, Сангийн яам болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн ажилчдад сургалт зохион байгууллаа.


ЭЗСЭШХ-ийн судлаачид 2013 оноос хойш CGE загварыг хөгжүүлж, бодлогын нөлөөллийн судалгаанд ашиглаж байна. CGE загвар нь эдийн засаг дахь шокуудыг нөлөөллийн үнэлгээнд өргөнөөр ашиглагддаг, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хэрэгсэл юм. CGE загвар нь эдийн засгийг макро түвшинд авч үзэхээс гадна эдийн засгийн салбаруудын задаргааг агуулдаг өргөн хүрээний эдийн засгийн загваруудын ангилалд багтдаг. CGE загваруудын суурь тоон мэдээлэл нь эдийн засгийг бүхэлд нь төлөөлөхүйц Нийгмийн тооцооллын матриц зэрэг үндэсний тооцооны хүснэгтүүд байдаг.

Загварт эдийн засгийн салбарууд болон агентуудын хоорондын хамаарлыг суурь тоон мэдээллээс олж авах бөгөөд үүнийгээ бодлогын үр нөлөөг тооцоолоход ашигладаг. Энэ нь загварын системийн зөвхөн нэг салбарт шок үүссэн ч бусад салбарууд болон агентуудад шууд бусаар нөлөөлнө гэсэн үг юм. Иймээс энэ төрлийн загварчлалууд шокийн нөлөөллийн шинжилгээний оновчтой хэрэгсэл байж чаддаг. Энгийнээр, CGE загвар нь m тэгшитгэл (эрэлт, нийлүүлэлт, зах зээлийн тэнцвэр болон макро эдийн засгийн агрегатууд) болон n хувьсагч (биет хэмжээ, үнэ, үнийн индекс, нэрлэсэн цалин болон агрегатууд)-ийн систем юм:

$$F(X,Y) = 0$$

энд, F нь m тэгшитгэлийн вектор, Y нь m эндоген хувьсагчдын вектор ба X нь $n-m$ экзоген хувьсагчдын вектор юм. Тодруулбал, X вектор дахь хувьсагчид экзогеноор өөрчлөгдөх үед загвараас Y буюу эндоген хувьсагчдын шийдийг олно. Жишээ нь, X векторт экспортын уул уурхайн бүтээгдэхүүний үнэ, үйлдвэрлэлийн тоо хэмжээ, гадаадын шууд хөрөнгө оруулалт, татварын түвшнүүд, засгийн газрын бараа, үйлчилгээний зардал болон бодит хөрөнгө оруулалт зэрэг хувьсагчид багтана. CGE загвараар шокийн нөлөөллийг үнэлэхдээ хувилбаруудыг боловсруулан харьцуулан дүгнэдэг. Судлаач эхлээд X -ийн тодорхой утгууд, түүнд харгалзах Y утгууд бүхий суурь хувилбарыг тодорхойлно. Дараа нь X -ийн нэг (эсвэл хэд хэдэн) экзоген хувьсагчийн утгыг өөрчлөн бодлогын хувилбарыг тодорхойлно. Ийнхүү бодлогын хувилбарын Y вектор дэх хувьсагчдын үр дүнг суурь хувилбартай харьцуулах замаар шокийн нөлөөллийг тооцоолно (Зураг 1).

Зураг 1. CGE загвараар бодлогын нөлөөллийг үнэлэх нь



Энэхүү төслийн хүрээнд манай хүрээлэнгийн судлаачид ЭЗХЯ-ны хүсэлтийн дагуу гурван бодлогын симуляцын шинжилгээ хийсэн. Эдгээр симуляцын хураангуйг дор багтаав.

Төсвийн хумих бодлогын хөдөлмөрийн зах зээлд үзүүлэх нөлөө: 2017 - 2021

2017 оны 5-р сард Засгийн газар эдийн засгийн хямралаас сэргийлэх, төсвийн тогтвортой байдлыг хангах зорилгоор ОУВС-тай хэлэлцээр хийсэн. Тус хэлэлцээрийн хүрээнд Засгийн газар төсвийн зарлагаа танаж, орлогоо нэмэгдүүлэх буюу төсвийн хэмнэлтийн бодлого хэрэгжүүлэх үүрэг хүлээв. Энэхүү судалгаагаар ОУВС-ийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх төсвийн хэмнэлтийн бодлогын хөдөлмөрийн зах зээлд үзүүлэх нөлөөг 2014 оны Монголын НТМ-д суурилсан динамик CGE загварыг ашиглан үнэлсэн.

Шинжилгээний хувилбаруудыг боловсруулахдаа, суурь хувилбарт загвараас 2016 оны эдийн засгийн бүтцийг гаргаж, 2017 -2021 онд ОУВС-ийн төсөөллийг тусгасан. Өөрөөр хэлбэл, суурь хувилбарт Засгийн газар төсвийн хэмнэлтийн бодлогыг хөтөлбөрийн анх тавьсан зорилтын дагуу хэрэгжүүлнэ гэж таамаглав. Харин бодлогын хувилбарт төсвийн хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэхгүй гэж таамаглав. Тодруулбал, бодлогын хувилбарт бид Онцгой албан татвар, Импортын тариф, Нийгмийн даатгалын шимтгэл болон Хувь хүний орлогын албан татварын өөрчлөлтүүд болон засгийн газрын худалдан авалт, зарцуулалтын амлалтыг биелүүлэхгүй гэж үзэв.

Түүнчлэн, Засгийн газар энэхүү хөтөлбөрийн хүрээнд төсвийн тогтвортой байдлыг хангахын тулд АХБ, Дэлхийн банк болон Япон болон Солонгос улсын засгийн газруудаас хөнгөлөлттэй зээл авахаар тохиролцсон. Бодлогын хувилбарт эдгээр зээлүүд олгогдохгүй бөгөөд Засгийн газар өндөр хүүтэй арилжааны зээл авна гэж таамаглав. Ийнхүү бид суурь болон бодлогын хувилбар дахь хувьсагчдын утгын зөрүүгээр төсвийн хэмнэлтийн бодлогын эдийн засаг дахь нөлөөг үнэлсэн.

Шинжилгээний хувилбаруудыг боловсруулахдаа, суурь хувилбарт загвараас 2016 оны эдийн засгийн бүтцийг гаргаж, 2017 -2021 онд ОУВС-ийн төсөөллийг тусгасан. Өөрөөр хэлбэл, суурь хувилбарт Засгийн газар төсвийн хэмнэлтийн бодлогыг хөтөлбөрийн анх тавьсан зорилтын дагуу хэрэгжүүлнэ гэж таамаглав. Харин бодлогын хувилбарт төсвийн хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэхгүй гэж таамаглав. Тодруулбал, бодлогын хувилбарт бид Онцгой албан татвар, Импортын тариф, Нийгмийн даатгалын шимтгэл болон Хувь хүний орлогын албан татварын өөрчлөлтүүд болон засгийн газрын худалдан авалт, зарцуулалтын амлалтыг биелүүлэхгүй гэж үзэв. Түүнчлэн, Засгийн газар энэхүү хөтөлбөрийн хүрээнд төсвийн тогтвортой байдлыг хангахын тулд АХБ, Дэлхийн банк болон Япон болон Солонгос улсын засгийн газруудаас хөнгөлөлттэй зээл авахаар тохиролцсон. Бодлогын хувилбарт эдгээр зээлүүд олгогдохгүй бөгөөд Засгийн газар өндөр хүүтэй арилжааны зээл авна гэж таамаглав. Ийнхүү бид суурь болон бодлогын хувилбар дахь хувьсагчдын утгын зөрүүгээр төсвийн хэмнэлтийн бодлогын эдийн засаг дахь нөлөөг үнэлсэн.

Симуляцын гол үр дүнгүүдээс товч дурдвал:

- Бодлогын хувилбарт төсвийн алдагдал болон засгийн газрын алдагдал суурь хувилбартай харьцуулахад өндөр байв. Иймд засгийн газрын хөрөнгө оруулалт буурч улмаар эдийн засаг дахь нийт хөрөнгө оруулалт бага байв.
- Бодлогын хувилбар дахь ДНБ-ий бүрэлдэхүүнүүдийг авч үзвэл хувийн хэрэглээ, засгийн газрын хэрэглээ болон цэвэр экспорт суурь хувилбартай харьцуулахад өндөр ч хөрөнгө оруулалт бага байв. Нийт дүнгээрээ ДНБ бодлогын хувилбарт арай бага байв. Энэ нь төсвийн хэмнэлтийн бодлого урт хугацаандаа ДНБ-д эерэг нөлөөтэйг харуулж байна.
- Салбараар авч үзвэл, суурь хувилбар буюу төсвийн хэмнэлтийн бодлого хэрэгжих үед боловсрол, эрүүл мэнд болон төрийн удирдлага зэрэг Засгийн газрын худалдан авалтын дийлэнх хувийг эзэлдэг салбарууд агшив. Эсрэгээрээ, барилга зэрэг хөрөнгө оруулалтад ихээр ашиглагддаг салбарууд тэлэв.
- Суурь хувилбар буюу төсвийн хэмнэлтийн бодлого хэрэгжих үед ажил эрхлэлт арай бага, цалингийн түвшин өндөр байв. Гэхдээ хөдөлмөрийн зах зээл дэх нөлөө нь салбаруудын хувьд ялгаатай байв. Тухайлбал, суурь хувилбарт хөрөнгө оруулалтын нөлөөгөөр хөдөө аж ахуй, барилгын салбарын үйлдвэрлэл хамгийн өндөр тэлснээр хөдөө аж ахуй, аж үйлдвэр, барилга болон гар урлалын салбар дахь ур чадвартай хөдөлмөрийн ажилгүйдлийн түвшин хамгийн ихээр буурав. Харин мэргэжилтэн, техникч болон туслах мэргэжилтэн зэрэг дундаж ур чадвартай хөдөлмөрийн ажилгүйдлийн түвшин өсөх хандлагатай байв. Хүйсээр авч үзвэл, төсвийн хэмнэлтийн бодлого хэрэгжих үед эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт эмэгтэйчүүдтэй харьцуулахад арай ихээр нэмэгдэж байв.

Төрийн бүтээмжийн сэргэлтийн бодлогын эдийн засаг дахь нөлөө

2021 оны 11-р сард УИХ-аас 10 жилийн хугацаанд хэрэгжүүлэх “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг баталсан. Энэхүү бодлогын зургаан дэд зорилтын нэг нь төрийн салбарын бүтээмжийг нэмэгдүүлж, авлигыг бууруулахад чиглэсэн Төрийн бүтээмжийн сэргэлтийн бодлого байв.

Энэхүү судалгаагаар бид Төрийн бүтээмжийн сэргэлтийн бодлогын эдийн засаг дахь нөлөөг 2018 оны НТМ-д суурилсан динамик CGE загварыг ашиглан үнэлсэн. Тодруулбал, бид PEP-1-t (Decaluwé болон бусад, 2013) загварыг өргөтгөж ашигласан. Тухайлбал, бид тус загварт шинээр цалингийн тэгшитгэл, нийт эдийн засгийн болон салбарын технологийн дэвшил, авлигын урсгал нэмснээс гадна хөрөнгө оруулалтыг хувийн болон улсын гэж хуваасан.

Ерөнхийдөө, симуляцын үр дүнгээс харахад төрийн салбарын бүтээмжийн өсөлт болон авлигын бууралт нь эдийн засагт эерэг нөлөөтэй байв. Тухайлбал:

- Төрийн удирдлагын салбарын бүтээмж өссөнөөр тус салбарын үйлдвэрлэл өсөв.
- Төрийн удирдлагын салбарын бүтээмж өссөнөөр хөдөлмөр төрийн салбараас хувийн салбар руу шилжив. Эдийн засаг дахь хөдөлмөр багтаамж ихтэй салбараас багтаамж багатай салбар уруу шилжсэнээр нэрлэсэн цалин буурав.
- Төрийн бүтээмжийн бодлого хэрэгжих хувилбарыг огт хэрэгжихгүй байх хувилбартай харьцуулахад бодит ДНБ 3 нэгж хувиар өндөр байв.
- Цалин буурч, авлигын орлого буурснаар хувийн секторын нэрлэсэн орлого буурав. Улмаар хувийн секторын нэрлэсэн хадгаламж буурав. Гэхдээ ХҮИ-ийн өөрчлөлтөөр засварласан бодит орлого өсөв.
- Өрхийн орлого буурснаар Засгийн газрын шууд татварын орлого буурсан ч үйлдвэрлэлийн болон бүтээгдэхүүний татвар өссөнөөр нийт дүнгээрээ төсвийн орлого өсөж, төсвийн хөрөнгө оруулалт өсөв.
- Хувийн хадгаламж буурсан ч төсвийн хөрөнгө оруулалтын нөлөөгөөр нийт хөрөнгө оруулалт өсөв.

Хүүхдийн мөнгөний хөтөлбөрийн нөлөө – өрхийн орлогын бүлгээр

Энэхүү судалгаагаар бид Хүүхдийн мөнгө хөтөлбөрийн өрхийн орлогын ялгаатай бүлгүүд болон эдийн засаг дахь нөлөөг статик CGE загварыг ашиглан үнэлсэн. Ингэхийн тулд бид 2018 оны НТМ дахь өрхийн дансыг орлогын түвшнээр 5 хувааж ашигласан. Энэ симуляцид бид дараах 3 хувилбарыг боловсруулан харьцуулж, дүгнэсэн.

- Суурь хувилбар: Хүүхдийн мөнгө хөтөлбөрт 18-аас бага настай хүүхэдтэй бүх өрх хамрагдана.
- Бодлого хувилбар 1: Хүүхдийн мөнгийг зөвхөн хамгийн бага орлоготой 20%-д багтах өрхөд олгоно. Засгийн газар хүүхдийн мөнгөнөөс хэмнэсэн төсвийн алдагдал болон хөрөнгө оруулалтаа санхүүжүүлнэ.
- Бодлогын хувилбар 2: Хүүхдийн мөнгийг зөвхөн хамгийн бага орлоготой 20%-д багтах өрхөд олгоно. Засгийн газар төсвийн алдагдлаа тогтмол хадгалах замаар хүүхдийн мөнгөнөөс хэмнэсэн мөнгөө бараа, үйлчилгээний худалдан авалтад зарцуулна.

Ерөнхийдөө, хүүхдийн мөнгөний халамжийг бууруулах нь макро эдийн засагт эерэг нөлөөтэй байв. Тухайлбал:

- Бодлогын 2 хувилбарыг суурь хувилбартай харьцуулахад бодит ДНБ өндөр байв.
- Бодлогын хувилбар 1-т Засгийн газрын орлого нэмэгдсэн ч урсгал зардал тогтмол тул хөрөнгө оруулалтын эх үүсвэр нэмэгдэж, төсвийн тэнцэл сайжрав. Үр дүнд нь эдийн засаг дахь нийт хөрөнгө оруулалт нэмэгдэж, барилга зэрэг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг салбарын үйлдвэрлэл өсөв.
- Бодлогын хувилбар 2-т төсвийн алдагдал тогтмол тул хүүхдийн мөнгөнөөс хэмнэсэн бүх мөнгө Засгийн газрын бараа, үйлчилгээний худалдан авалтад зарцуулагдана. Иймд төрийн удирдлага зэрэг төрийн салбарууд тэлэв. Харин нөгөө талдаа өрхийн орлого, хадгаламж буурснаар хөрөнгө оруулалтын эх үүсвэр буурч барилга зэрэг хөрөнгө оруулалтын салбар агшив. Нийт дүнгээрээ, хувийн секторын хөрөнгө оруулалт агшив.
- Өрхийн орлогын бүлгээр авч үзвэл, хүүхдийн мөнгийг олгохгүй байснаар 2 болон 3-р бүлгийн өрхүүдийн орлого хамгийн ихээр буурч байв.

ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО: ӨНГӨРСӨН БА ИРЭЭДҮЙ

Энэхүү төслийг USAID-ын санхүүжилттэй Хөгжлийн Шийдэл ТББ-ын хэрэгжүүлж буй BEST хөтөлбөрийн захиалгаар 2022 оны 5-р сараас 9-р сарын хугацаанд хэрэгжүүлэв. Төслийн хүрээнд гурван цуврал сэдвээр судалгаа хийж, сэдэв тус бүр дээр хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Эхний судалгаа нь “Эдийн засгаа эрчимжүүлэх хөтөлбөрийн хувийн секторын үр нөлөө, сургамж” сэдэвтэй бөгөөд энд Засгийн газраас 2021 онд хэрэгжүүлсэн Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнгийн талаарх судалгаа, статистик тоон мэдээлэл, тайлангуудад тойм шинжилгээ хийсэн. Уг цогц төлөвлөгөө нь эдийн засаг унасан үед зээлийн өсөлтийг сэргээж, зээлийн хүүг бууруулж, ажил эрхлэлт, хөрөнгө оруулалтыг дэмжиж, бизнесийн идэвхжилээр дамжин төсвийн орлого бүрдүүлэхэд эерэг нөлөө үзүүлснийг Дэлхийн Банкны 2022 онд нийтэлсэн “Монгол Улсын эдийн засгийн тойм: Шуурган дунд зүг чигээ олохуй” тайланд дурджээ. Гэхдээ эдийн засгийн дотоод идэвхилийг дэмжих зорилготой санхүүжилттэй урсгал тэнцлийн алдагдал өссөн нь давхацсан байна.

Хил гаалийн хязгаарлалт үргэлжилж байгаа үед нийлүүлэлтийн тасалдалтаас үүдэлтэй өсөж байсан инфляцыг энэ цогц төлөвлөгөө хэрэгжсэнээр улам хөөрөгджээ. Хүнс, өргөн хэрэглээний бараа үйлчилгээний үнэ төдийгүй барилгын материал, орон сууц гэх мэт бүх салбарт үнийн өсөлт хурдтай явагдаж байна. Мөн энэ цогц төлөвлөгөө нь ажлын байрны дийлэнхийг бүрдүүлдэг, гол тусламж дэмжлэг шаардлагатай жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд төдийлөн дэмжлэг үзүүлж чадаагүй байна. Өөр нэг анхаарах зүйл бол 10 их наядын цогц төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнгийн талаар нэгдсэн тайлан ховор, нарийвчилсан үнэлгээ хийхэд шаардлагатай тоон мэдээлэл нээлттэй биш, хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээ яаж хийгдэж байгаа нь тодорхойгүй байна.

“Шинэ сэргэлтийн бодлого ба хувийн секторын хүлээлт” хэмээх хоёр дахь судалгаанд бид УИХ-аас 2021 оны 12-р сард баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын үндэслэл, хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээ, цаашид анхаарах асуудлын талаарх тоймыг хүргэсэн. Уг бодлого нь Монгол Улсын эдийн засгийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх, цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлийг цаг алдалгүй шийдвэрлэж, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засаг, дэд бүтэц болон төрийн бүтээмжийг сайжруулахад чиглэсэн 2030 он хүртэл хэрэгжих дунд хугацааны зорилтот хөтөлбөр юм. Шинэ сэргэлтийн бодлогын нэг онцлог нь уг бодлогыг Өсөлтийн оношилгоо (growth diagnostic) хэмээх олон улсад өргөн хэрэглэдэг аргачлалд үндэслэсэн явдал юм. Засгийн газар энэ аргачлалыг ашиглан Монголын эдийн засгийг хязгаарлагч 6 хүчин зүйлсийг тодорхойлж, Шинэ сэргэлтийн бодлогоо томъёолжээ.

Уг бодлого нь хилийн боомтын хязгаарлалт, эрчим хүчний хязгаарлалт, аж үйлдвэрийн салбарт тулгамдаж буй асуудал, хот ба хөдөөгийн хөгжлийн асуудал, ногоон хөгжлийн сэргэлт, төрийн бүтээмжийн сэргэлт гэсэн 6 багц хүрээг хамарна. Эдгээр хязгаарлагч хүчин зүйлс нь яах аргагүй манай улсын эдийн засгийн өсөлт, хөгжилд олон жилийн турш тулгамдаж ирсэн асуудлууд мөн. Гэхдээ гол асуудал нь Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд төлөвлөсөн багц зорилтууд, 94 төсөл арга хэмжээг ач холбогдлоор нь эрэмбэлэх, хамгийн чухлаас эхэлж хэрэгжүүлэхэд нөөцийг хуваарилах явдал юм.

Энэ төслийн хүрээнд гүйцэтгэсэн гурав дахь судалгаа нь “Цар тахлын үеийн ЖДҮ-ийн салбарын бодлого: Олон улсын туршлага” сэдэвтэй. Тус судалгаа нь цар тахлын хүндрэлтэй үед бусад улс орон, олон улсын донор байгууллагууд хувийн хэвшлийн үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг дэмжих чиглэлээр ямар арга хэмжээ авсан, үүнээс ямар сургамж авч болохыг тодруулахыг зорьсон. Тухайлбал, Азийн Хөгжлийн Банк, Дэлхийн Банк, Олон Улсын Валютын Сан зэрэг донор байгууллагууд цар тахлын хүндрэлтэй үед хувийн хэвшлийг дэмжих чиглэлээр ямар арга хэмжээ авч, ямар дүгнэлт, бодлогын зөвлөмж өгч байгааг тоймлон авч үзсэнээс гадна Хятад, Өмнөд Солонгос, Вьетнам, Казакстан зэрэг бүс нутгийн орнуудын цар тахлын үеийн бодлого, тэдгээрийн үр дүн, сургамжийн талаар тодруулсан юм.

Ковид-19-ийн үед улс орнуудад бичил, жижиг дунд бизнесийн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогууд ерөнхийдөө хоорондоо төстэй бөгөөд дараах төрлийн үндсэн арга хэмжээнүүдийг авч байжээ. Үүнд:

- ЖДҮ-ийн хөрвөх чадварыг дэмжих буюу татвар, нийгмийн даатгалын хөнгөлөлт, чөлөөлөлт
- Банкны зээлийн төлөлтийг хойшлуулах
- Хөнгөлөлттэй зээл олгох, санхүүгийн хүртээмж нэмэх, батлан даалтын санг өргөжүүлэх
- Дулаан, цахилгаан, түрээсийн төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх
- Ажил эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг хадгалах, татаас олгох
- Үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, төрөөс хэрэгжүүлж буй дэмжлэгт хамруулахын тулд бүртгэж албан бусаас албан секторт шилжихийг дэмжих
- Эрүүл мэндийн тоног төхөөрөмж, материалын үйлдвэрлэлийг дэмжих, дижитал шилжилтийг дэмжих, ЖДҮ-ийн онлайн борлуулалт, хүргэлтийг идэвхжүүлэх

Манай улсын хувьд цар тахлын үед дээрх чиглэлүүдээр бодлогын цуврал олон арга хэмжээ хэрэгжүүлсэн. Гэхдээ эдгээр бодлого хэр үр дүнтэй байх нь тухайн ажлын зохион байгуулалт, нарийвчилсан дүрэм журам, шаардлагатай урьдач нөхцөлүүд бүрэлдсэн эсэх гэх мэт олон хүчин зүйлээс хамаарна.

Цар тахлын үед ЖДҮ-ийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, туршлага, үр дүн, олон улсын байгууллагуудаас боловсруулсан зөвлөмжөөс дараах гол сургамжуудыг авч болохоор байна. Үүнд:

- Мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх
- Үүрэг хариуцлагыг тодорхой болгох
- Зорилтот бүлгүүдийг зөв, цаг алдалгүй тодорхойлох
- Тусламж, дэмжлэгийг зорилтот бүлгүүдэд онцлогт нь тохируулж хэрэгжүүлэх
- Төрийн үйлчилгээг шуурхай болгох
- Нөөц бүрдүүлэх, эрсдэлийн төлөвлөгөө гаргах
- Хүндрэл бэрхшээлийг боломж болгож хувиргах
- Цар тахлын дараах ЖДҮ эрхлэгчдийг дэмжих бодлого боловсруулах
- Бизнесийн хөгжлийн үйлчилгээ, ур чадвар дээшлүүлэх сургалт орох
- Санхүүжилтээр хангах
- Бодлого хэрэгжүүлэхдээ хувийн секторын нөөцийг илүү ашиглах

БАГА, ДУНД БОЛОВСРОЛ ЭЗЭМШҮҮЛЭХЭД НЭГ СУРАЛЦАГЧИД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН ДУНДАЖ НОРМАТИВЫГ ТООЦОХ АРГАЧЛАЛ БОЛОВСРУУЛАХ, ТУРШИХ

Боловсрол, шинжлэх ухааны яамны захиалгаар “Макро эдийн засаг ба эрүүл мэнд” ТББ-тай хамтран гүйцэтгэсэн энэхүү судалгаа нь ерөнхий боловсролын сургуулийн (ЕБС) бага, дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг тооцох аргачлалыг боловсронгуй болгох, сайжруулах санал, зөвлөмж боловсруулах зорилготой.

Энэ судалгаанд эхлээд Монгол Улс дахь ЕБС-ийн санхүүжилтийн өнөөгийн тогтолцоог боловсролын салбарын төсвийн сүүлийн жилүүдийн хандлага, ЕБС-ийн санхүүжилтийн талаарх эрх зүйн зохицуулалт талаас нь салбарын статистик, баримт бичгийн тойм шинжилгээгээр тодруулсан. Дараа нь ЕБС-ийн зардлын бүтцийн нарийвчилсан дүн шинжилгээг нийслэлийн ЕБС-уудын төсөв, зардлын бодит тоон мэдээлэл ашиглан гүйцэтгэв. Шинжилгээнээс харахад, боловсролын салбарын санхүүжилт нь эдийн засгийн өсөлт, инфляцын түвшин, хүн амд эзлэх хүүхдийн тооны өсөлтөөс ихээхэн хоцорч байна. Нийслэлийн төрийн өмчийн ЕБС-ийн үйл ажиллагааны зардлын дийлэнх нь буюу 84% нь багш ажилчдын цалин, урамшуулал, тэдний нийгмийн даатгалын шимтгэлд зарцуулагддаг байна. Гэвч боловсролын салбарын ажиллагсдын дундаж цалин сүүлийн жилүүдэд улсын дунджаас 20% орчим доогуур байна.

Иймд ЕБС-ийн нэг сурагчид ногдох хувьсах зардлын нормативыг шинэчлэхдээ дээрх гажуудлыг засах шаардлагатай. Үүнтэй холбоотойгоор судалгааны баг норматив шинэчлэх хувилбар тооцоог гүйцэтгэж, хэрэгжүүлэхэд тулгарч болзошгүй эрсдэлийг тодорхойлсон. Энд мөн хувьсах зардлын санхүүжилтийг томъёонд үндэслэн тодорхойлох олон улсын туршлагыг тоймлон авч үзсэн бөгөөд энд Английн жишээг гүнзгийрүүлэн судаллаа. Английн хувьсах зардлын норматив тооцох аргачлал нь энгийн болон тусгай хэрэгцээт сургууль гэсэн хоёр хувилбартай. Уг аргачлалд тухайн хүүхдийн шинж чанараас хамаарсан орлогын гачигдал, сурлагын хоцрогдол, эх хэл, шилжих хөдөлгөөн болон сургуулийн байршлаас хамаарсан алслагдмал байдал, орон нутгийн хөдөлмөрийн зах зээл, орон нутгийн үнийн түвшин гэх мэт үзүүлэлтийг харгалзан үздэг байна.

Судалгааны дүр дүнд үндэслэн Монголын ЕБС-ийн санхүүжилтийн томъёог нарийвчилж тодорхойлохдоо үнэлгээ хийх үндсэн зарчмууд болох тэгш байдал, хангалттай байдал, үр ашигтай байдал, ил тод хариуцлагатай байдал, захиргааны зардал гэх мэт шалгуурыг зайлшгүй харгалзан үзэх, орцоор ангилал зааж зардлыг санхүүжүүлэхээс илүүтэй үр дүнд суурилах аргачлалыг санал болгов.

Сургалтын хөтөлбөрийн өртөг тооцооллыг үйлдэлд суурилсан өртөг тооцох аргачлалаар хийх жишиг загвар боловсруулах

Боловсрол, шинжлэх ухааны яамны захиалгаар “Макро эдийн засаг ба эрүүл мэнд” ТББ-тай хамтран гүйцэтгэсэн энэхүү хоёр дахь судалгаа нь ЕБС-ийн өртөг тооцох аргачлалын жишиг загварыг боловсруулах, өртгийн тооцооллыг сургуулиуд дээр турших, зарим хөтөлбөрийн сургалтын өртгийн харьцуулалт хийж зөвлөмж боловсруулах зорилготой. Энэ хүрээнд судалгааны баг сургалтын хөтөлбөрийн өртгийн тооцооллыг үйлдэлд суурилсан өртөг тооцох аргачлалаар хийх жишиг загварыг боловсруулахын тулд нийслэлээс сонгосон хоёр сургуулийн 2019, 2020 оны санхүүгийн дэлгэрэнгүй бүртгэл мэдээлэл, тоон өгөгдөлд аргачлалын дагуу дүн шинжилгээ хийсэн.

Үүнд эхлээд, сургуулиудын санхүүжилтийн өнөөгийн өртгийн тооцоог дээрээс доош (top down) аргачлалаар хийсэн тооцооллын үр дүнтэй харьцуулсан. Үүний дараа сонгосон сургуулиудын сургалтын хөтөлбөрийн өртгийн тооцооллыг үйлдэлд суурилсан өртгийн (activity based costing-ABC) аргачлалаар нарийвчлан гүйцэтгэсэн. Улмаар ABC аргачлалын тооцоонд үндэслэн бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг хэд хэдэн хувилбараар тооцсон. Эцэст нь, сонгосон сургуулиудад хөтөлбөр хэрэгжүүлэхэд гарч буй дундаж зардлыг бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшнээр болон дээрх хувилбаруудаар тооцож харьцуулалт хийв.

Үйлдэлд суурилсан өртгийн аргаар Боловсролын стандартад заасан хөтөлбөр хэрэгжүүлэх бүрэн зардлыг тооцож үзэхэд 2020 оны байдлаар нэг сурагчид ногдох зардал нь бага боловсролд 1.3-1.4 сая, суурь боловсролд 1.6-2.5 сая, бүрэн дунд боловсролд 1.9-2.1 сая төгрөг болж байсан. Гэхдээ энд орон нутгийн төсвөөс санхүүжих тогтмол зардал болон зарим нэр төрлийн хичээл практикийн зардлыг тооцоогүй. Гэсэн хэдий ч төсвөөс ЕБС-д олгож буй өнөөгийн хувьсах зардал нь стандартын дагуу боловсрол олгоход шаардагдах зардлаас дор хаяж хоёр дахин бага байгаа юм.

Иймээс ЕБС-ийн олгох боловсролын хөтөлбөрийн чанарыг стандартад хүргэхийн тулд санхүүжилтийг эрс нэмэгдүүлэх шаардлагатай байна. Мөн үйлдэлд суурилсан өртөг тооцох арга зүйг ашиглан сургалтын хөтөлбөрийг өөрийн өртгөөр тооцдог тогтолцоог нэвтрүүлбэл төсвийг оновчтой төлөвлөх, гүйцэтгэлийг үнэлэх, салбарын үр ашгийг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗУДЫН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ (ЦАГ УУРЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ АРГА ХЭМЖЭЭ) БОЛОН МАЛЧДЫН ЗУДЫГ ТЭСВЭРЛЭХ ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ СУДАЛГАА

Энэхүү судалгааг Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА)-ын “Монгол улсын зудын эрсдэлийг бууруулах арга хэмжээ (цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээ) болон малчдын зудыг тэсвэрлэх чадавхыг бий болгох” төслийн нэгжийн захиалгаар хийж гүйцэтгэсэн бөгөөд Дундговь болон Говь-Алтай аймгийн малчдын байгалийн гамшигт дасан зохицох чадавхыг судлахыг зорьсон. Түүнчлэн зудын урьдчилсан мэдээний ашиглалтын нөхцөл байдал, мал, махны борлуулалтын сувгийн нөхцөл байдлыг судлах зорилготой юм.

Уг судалгаагаар баримт бичгийн тойм шинжилгээ, талбарын түүвэр судалгааны тоон ба чанарын шинжилгээг хийсэн. Судалгааны үндсэн мэдээллийг талбарын судалгаагаар цуглуулсан. Талбарын ярилцлагуудад малчид, орон нутгийн төрийн албан хаагчид, махны нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч талууд болон орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг хамруулсан. Малчдаас мэдээлэл цуглуулахдаа бүтэцлэгдсэн асуумж хэрэглэхээс гадна болон сум бүр дээр бүлгийн ярилцлага зохион байгуулсан. Малчид, орон нутгийн удирдлагуудтай хийсэн ярилцлага нь зудын урьдчилсан мэдээний ашиглалт, зудад бэлтгэх, зудыг даван туулах чадавхыг тодорхойлохыг зорьсон бол махны нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч талуудтай хийсэн ярилцлага нь мах нийлүүлэлтийн сүлжээний асуудлуудыг тодорхойлохыг зорьсон.

Судалгааны зорилтот бүс нутаг нь зудын эрсдэл өндөртэй Дундговь аймаг, Говь-Алтай аймгийн сумд юм. Аймаг бүрээс хоёр сум сонгож судалгааг явуулсан бөгөөд Дундговь аймгаас Гурвансайхан, Адаацаг сумууд сонгогдсон бол Говь-Алтай аймгаас Бигэр, Цогт сумууд сонгогдсон. Түүнчлэн, аймгийн төвүүд (Мандалговь сум, Есөнбулаг сум) дэх махны нэмүү өртгийн сүлжээний холбогдох талууд болон төрийн албан хаагчидтай ярилцлага хийсэн.

Малчин өрхийн судалгаанд Дундговь болон Говь-Алтай аймгийн 212 өрх хамрагдсан. Малчдаас өрхийн ерөнхий мэдээлэл, хөрөнгө ба мал, харилцаа холбооны нөхцөл байдал, өрхийн эдийн засгийн байдал, зудаас урьдчилан сэргийлэх болон зудыг даван туулах чадавх зэрэг сэдвүүдийн хүрээнд мэдээлэл цуглуулсан. Орон нутгийн төрийн байгууллагуудаас байгалийн гамшгийн талаарх мэдээлэл түгээлтийн нөхцөл байдлыг тодруулахыг зорьсон. Харин махны нэмүү өртгийн сүлжээнд оролцогчдоос борлуулалтаа хэрхэн хийдэг болон ямар бэрхшээл тулгардаг талаар мэдээлэл цуглуулсан.

СУМДЫН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ – 2022

Дэлхийн банкны “Тогтвортой амьжиргаа-3” төслийн захиалгаар Орон нутгийн хөгжлийн сан (ОНХС)-ийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээг гүйцэтгэв. Үнэлгээнд Баян-Өлгий, Завхан, Увс, Ховд, Хөвсгөл, Орхон зэрэг 6 аймгийн 98 сумыг хамруулсан. Уг судалгаагаар сумдын ОНХС-ийн 2021-2022 оны үйл ажиллагаа иргэдийн оролцоо, ил тод байдлыг хэрхэн хангасан, төсвийг хэрхэн төлөвлөсөн, сангийн төсвийн гүйцэтгэлд хэрхэн хяналт тавьсныг тусгай шалгуураар үнэлдэг. Мөн энэ жилийн үнэлгээгээр судалгааны баг аймаг тус бүрийн чадавхжуулах багийн мэргэжилтнүүдэд ОНХС-ийн онлайн системээр үнэлгээг хэрхэн хийх сургалт зохион байгуулж, тухайн аймгийн сумдын ОНХС-ийн системээс хийх үнэлгээг хамтран гүйцэтгэсэн.

2022 ОНЫ ХУРАЛ

Эдийн Засгийн Судалгаа Эрдэм Шинжилгээний Хүрээлэн (ЭЗСЭШХ) нь 2022 онд хоёр удаагийн олон улсын хурлыг амжилттай зохион байгууллаа.

2022 оны 1-р сарын 18-ны өдөр "УУЛ УУРХАЙ БА ЭДИЙН ЗАСАГ: ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ШИЙДЭЛ" сэдэвт хурлыг Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА) болон Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн Яамтай хамтран зохион байгуулсан. Тус хурал дээр ЖАЙКА-ын төлөөлөгч Ёшитака Хосой судалгааны төсөл болон МИМ, МRM-ын талаар танилцуулсан бол ЭЗСЭШХ-ийн судлаачид "2021 онд хийсэн судалгааны танилцуулга", "Уул уурхайн салбарт КОВИД-19-ын үзүүлсэн нөлөө", "Нүүрстөрөгчийн хязгаарлалтад Монгол Улс дасан зохицох нь", "Уул уурхайн салбарын нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх бодлогын зөвлөмж", "Олборлолтын нийгмийн зөвшөөрлийн судалгаа" зэрэг судалгааны үр дүнг танилцуулсан. Эдгээр танилцуулгууд Англи, Монгол хэлээр ЭЗСЭШХ-гийн цахим хуудас www.eri.mn-д нийтлэгдсэн.

2022 оны 10-р сарын 25-ны өдөр "МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН АШИГТ МАЛТМАЛААС ХАРААТ БАЙДАЛ: ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ЗӨВЛӨМЖ" сэдэвт хурлыг мөн Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА) болон Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн Яамтай хамтран зохион байгуулсан. Тус хурал дээр ЖАЙКА-ын дэмжлэгтэйгээр 2016-2022 онд хэрэгжүүлсэн "Уул уурхай, ашигт малтмалын салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх" төслийн хүрээнд хийгдсэн бүх судалгааг танилцуулсан. Энэхүү төслийн хүрээнд 20 гаруй цуврал судалгаанууд хийгдсэн бөгөөд эдгээр судалгаанууд нь уул уурхайн орлогыг үр ашигтай удирдах, ГШХО-ыг дэмжих, шударга гэрээ хэлэлцээр хийх, уул уурхайн бүтээгдэхүүний худалдааг сайжруулах, уул уурхайн салбарыг тогтвортой хөгжүүлэхэд тулгарч буй бэрхшээлүүдийг илрүүлэх зэрэг сэдвүүдийг хамарсан.

"МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН АШИГТ МАЛТМАЛААС ХАРААТ БАЙДАЛ: ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ЗӨВЛӨМЖ" хурал нь 2022 оны 12-р сарын 7-ны өдөр Япон улсын Токио хотод англи хэл дээр мөн зохион байгуулагдсан бөгөөд тус хуралд ЭЗСЭШХ-гийн судлаачид бүрэн бүрэлдэхүүнээр оролцож, судалгаагаа танилцуулсан.

